

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Биелэлт
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН НЭР: ДОТООД ХЭРГИЙН БОДЛОГО					
ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР:					
Нэг. Шүүхийн шинжилгээ хийх.					
1. Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.					
1.1. Шүүхийн шинжилгээ хийхтэй холбогдон үүсэж буй харилцааг цогц байдлаар шийдвэрлэх, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, бүтэц, статусыг тодорхойлох, байгууллага болон шинжээч мэргэжилтний бие даасан, хараат бус байдлыг хангах, гадны нөлөөнд автахгүй байх, албан хаагчдын нийгэм, эдийн засаг, эрх зүй, аюулгүй байдлын баталгааг хангах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх.	0	1	Улсын төсөв, 80.0 сая төгрөг	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Шүүх шинжилгээний тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдаж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг болж бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон бөгөөд “цахим технологи, инженер техник, хөрөнгийн үнэлгээ болон байгаль орчны хохирлын үнэлгээ, гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох” зэрэг шинэ төрлийн шинжилгээнүүд хийх эрх зүйн орчин бүрдсэн (Төрийн мэдээлэл 2023 он, Дугаар 05, 1253)
2. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.					
2.1. Орон нутгийн Шүүхийн шинжилгээний албадын үйл ажиллагааг нэг жишигт /стандартад/ хүргэхийн	Орон нутагт барьсан шүүхийн шинжилгээний лабораторийн тоо.	3	18	-	Шүүх шинжилгээний тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагыг нутаг дэвсгэрийн, эсхүл тойргийн зарчмаар байгуулж болно” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын

<p>тулд нэг загварын лаборатори, хүний нөөц, хэрэгцээт техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>				<p>2023 оны 182 дугаар тогтоолоор “Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд” аймагт бүсийн Шүүх шинжилгээний төвүүдийг байгуулахаар шийдвэрлэж, Дорнод аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төвийн нээлтийг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>Дорнод аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс тус тус стандартын шаардлагад нийцсэн нэг загварын лабораторийн зориулалт бүхий барилгыг бариулж, ашиглалтад хүлээн авч, үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Сэлэнгэ аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Улсын төсвийн санхүүжилт шийдэгдээгүй тул зарим аймгуудын шүүх шинжилгээний нэгжийн байрны асуудлыг балансаас балансад шилжүүлэн шийдвэрлэсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын дагуу Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн байрыг тус байгууллагын мэдэлд балансаас балансад шилжүүлэн авсан болно.</p> <p>Увс аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс Аймгийн засаг даргын 2023 оны А/249 тоот захирамжаар 1358м² газрыг балансаас балансад албан зориулалтаар 9 жилийн хугацаатай Улсын бүртгэлийн Э-1520002354 дугаартай эзэмших эрхийн гэрчилгээг авсан.</p> <p>Хэнтий аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс 0,15 га газрын Э-1817000221 улсын бүртгэлийн дугаартай гэрчилгээ авсан.</p>
<p>2.4. Митохондрин ДНХ-ийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулна.</p>	<p>Митохондрин ДНХ-ийн шинжилгээний лабораторийг байгуулсан эсэх.</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв, 900.0 сая төгрөг</p> <p>Метохондрин ДНХ-ийн шинжилгээний лаборатори байгуулахад шаардлагатай тооцоо, судалгааг хийж, арга зүйг боловсруулан /MNS 6718:2018/ стандартыг батлуулж, БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ДНХ-ийн шинжилгээний лабораторид “3500” генетик анализаторыг суурилуулан шинжилгээ хийх нөхцөл бүрдсэнээс гадна Ханнс-Зайделийн сангийн</p>

					<p>Монгол дахь төлөөлөгчийн газрын дэмжлэгээр 7 сая төгрөгийн өртөг бүхий багаж, техник хэрэглэгдэхүүнийг худалдан авч, яснаас дээж бэлтгэх шинжилгээний үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Үүний үр дүнд 2023 оны 12 сарын байдлаар санд бүртгэгдсэн ясанд ДНХ -ийн шинжилгээ хийж, эзэнгүй 2 хэргийн хохирогчийг нотлон ажилласан.</p>
<p>2.5. Криминалистикийн шинжилгээний газарт Экологийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулна.</p>	<p>Байгаль орчны бохирдол, хохирлын хэмжээг тодорхойлох экологийн шинжилгээг нэвтрүүлсэн хувь.</p>	0	30	Улсын төсөв	<p>Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2020 оны А/216 дугаар тушаалаар Криминалистикийн шинжилгээний газрын харьяанд “Экологийн шинжилгээний лаборатори”-ийг шинээр байгуулж, 6 шинжээчийг томилсон бөгөөд мөн Сайдын 2022 оны А/140 дүгээр тушаалаар Экологийн шинжилгээний лабораторийг бие даасан нэгж болгож, аймаг, орон нутгийг бүсчлэн хариуцах 8 шинжээчийн орон тоог шийдвэрлүүлэн, 2023 онд Дорнод, Ховд, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Баянхонгор аймгийн шүүх шинжилгээний хэлтэст нийт 4 шинжээч томилсон бол 2024 онд Нийслэлийн шүүх шинжилгээний газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтэс, Дархан-Уул, Өвөрхангай аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Архангай аймгийн шүүх шинжилгээний хэлтэст нийт 6 шинжээч томилж, тайлангийн хугацаанд 2021 онд 2, 2022 онд 92, 2023 онд 247 шинжилгээ, 2024 онд 310 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна.</p> <p>Хүрээлэн буй орчны шинжилгээний чиглэлээр 2022 онд 13,872,847,176 төгрөг, 2023 онд 4,727,512,207.84 төгрөг, 2024 онд 25,074,382,944 төгрөгийн экологи, эдийн засгийн үнэлгээ, хохирлын хэмжээг тогтоосон.</p> <p>“Экологийн шинжилгээний нэгдсэн сангийн журам”-ын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн бөгөөд 2023 онд аймгийн шүүх шинжилгээний хэлтсээс ирүүлсэн 2 зүйл амьтны дээжийг санд авсан бол 2024 онд 1 тооны цоохор ирвэс (үхсэн) ирүүлсэн.</p>
<p>2.6. Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын эд эсийн /иммуногистохимийн/ шинжилгээний</p>	<p>Хүчин чадлын хувь.</p>	70	100	Улсын төсөв	<p>Лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд “Синапс” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж “Халдвар хамгаалалтын ариутгалын хаалга”, “Biobase” загварын иммуногистохимийн бэлдэц бэлдэх зориулалттай, сорогч болон ариутгагчтай био аюулгүйн</p>

<p>лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.</p>					<p>шүүгээ, “Bel photonics” загварын гэрлийн 2 микроскоп, “Dpette” загварын электрон гар пипетик”, “Biobase” загварын эмнэлгийн зориулалттай хөргөгчийг нийт 38.3 сая төгрөгөөр худалдан авч иммуногистохимийн шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн.</p> <p>Үүний үр дүнд хүний биед гэмтэл үүссэн цаг хугацааг нарийвчлалтай тогтоох, амьсгал бүтэлтээр нас барсан эсэх, дүүжлэлт болон гэмтэл амьддаа үүсгэгдсэн эсэх, зүрхний цочмог шигдээсийн илэрдэггүй үхжлийг ялган оношлох боломжтой болсон.</p> <p>Шүүх анагаах ухааны шинжилгээний хэлтсийн тус лабораторид 2023 онд иммунногистохимийн будгийг шинээр нэвтрүүлж, БНХАУ-д үйлдвэрлэсэн “Биомед” микроскопи 2 ширхэг, “RoundFin” микротом, лаан, тосон цутгамал, шинжилгээний суурь урвалжууд, “S100” будаг зэргийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.</p> <p>Мөн 2024 онд “Biobase” компанийн “BSC-1100IIA2-X” загварын 1 ширхэг, “EA2-5F” загварын сорох шүүгээ 2 ширхэг, “Dakewe DP360” бүрэн автомат будгийн дамжлагын аппарат, “Olympus CX33” дэлгэцтэй дижитал микроскопи, шилэн бэлдэц хадгалах 240000 слайдын багтаамжтай шүүгээ, лаан блок хадгалах 28800 кассетны багтаамжтай шүүгээ зэрэг багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Түүнчлэн тус лабораторийн зүслэгийн өрөөнд бүрэн засварын ажил хийж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.</p> <p>Дээрх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр эд эсийн (иммуногистохимийн) шинжилгээний эдийн дамжлага сайжирч, хугацаа богиносж, будаг, урвалжийн зарцуулалт багасаж, шинжилгээний үр дүнд ахиц гарч, эдийн шинжилгээний архивын материалыг эвдрэл гэмтэлгүй хадгалах нөхцөл бүрдсэн.</p>
<p>3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.</p>					
<p>3.1. ДНХ-ийн нэгдсэн сан бий болгож шаардлагатай иж бүрэн техник, тоног</p>	<p>ДНХ-ийн нэгдсэн санг бий болгосон эсэх.</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж, гэмт хэрэгтнийг нотлон тогтоох болон санг бүрдүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ДНХ -ийн мэдээллийн сангийн “Mondis”</p>

<p>төхөөрөмж, программ хангамж, урвалж, бодис, хэрэгслийг худалдан авна.</p>				<p>хайлтын системийг хийсэн бөгөөд уг хайлтын систем нь “Иргэн”, “Ялтан”, “Гэмт хэрэг”, “Илрээгүй гэмт хэрэг” гэсэн үндсэн 4 ангилалтай бөгөөд ангилал тус бүрээр хайлт хийх, мэдээлэл оруулах, цаашид хөгжүүлэлт хийх боломжтой бөгөөд тус хайлтын системд нийт 2018 оноос хойш 8000 гаруй ДНХ -ийн мэдээллийг оруулж бүртгэсэн байна. Мөн ЦЕГ, ШШЕГ -тай хамтран хорих ангид ял эдэлж байсан хоригдол, өршөөлийн хуулиар суллагдсан ялтан, орон гэргүй тэнэмэл хүн, захиргааны хяналтад байгаа зэрэг нийт 10000 орчим хүнээс генетикийн дээж авч хадгалсан.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламж, тус улсын Аюулгүй байдал, дотоод хэргийн яамны харьяа Үндэсний Шүүх шинжилгээний хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 2023 онд ДНХ-ийн шинжилгээний лабораторид 26 төрлийн 66 ширхэг тоног төхөөрөмж, 34 төрлийн урвалж бодис, 12 төрлийн туслах хэрэглэгдэхүүнийг суурилуулж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн бөгөөд үүний үр дүнд Монгол улсад анх удаа санд бүртгэгдсэн ясанд ДНХ-ийн шинжилгээ хийж, эзэнгүй 2 хэргийн хохирогчийг нотлон ажилласан.</p> <p>ДНХ-ийн шинжилгээний лабораторийн “Генетик анализатор 3500XL” төхөөрөмж дахь 815 дээжийн ДНХ-ийн мэдээллийг санд оруулсан бөгөөд сангийн тохирол, хайлт, магадлалын статистик зэрэг бүх үзүүлэлтүүд хэвийн ажиллаж эхэлсэн.</p> <p>Ингэснээр ДНХ-ийн шинжилгээгээр эцэг, эх байх магадлалыг тооцож >99.99% байх магадлал (Basis statictic), хүн амд тухайн генетик профайл дахин давтагдах магадлал (Likelihood ratio), эцэг эсхүл эх биш гэсэн тохиолдлыг магадлалд таамаглал дэвшүүлэх (hypothesis H1, H2), Y хромосомын чиглэлээр мутацийн эрчим, хүн амд тухайн генетик профайл дахин давтагдах магадлал (Likelihood ratio) зэргийг автоматаар тооцоолох боломжтой болсон.</p>
--	--	--	--	--

					<p>Мөн геномын ДНХ-ийг ялгах, ялгарсан ДНХ-ийн агууламж, задрал, дээжид агуулагдаж буй эрэгтэй, эмэгтэй ДНХ-ийн ялгааг тогтоох зориулалт бүхий “real-time PCR”-ийн үр дүнг тооцон, сан бүрдүүлэх боломж бүрдсэн.</p> <p>Цаашид “MonDis” санд бүртгэлтэй дээжийг “CLIMS” системийн сан руу шилжүүлэхээр төлөвлөн ажиллахаас гадна шинэ дээжийг туршилтаар оруулж, харьцуулан шинжлэхээр ажиллаж байна.</p>
<p>3.2. “E-Nifs” улсын хэмжээний нэгдсэн системийг хөгжүүлж, цаг үеийн болон яаралтай мэдээ, мэдээлэл, сургалтын видео хичээл зэргийг байршуулж, сайжруулах.</p>	<p>Системийн хөгжүүлэлтийн хувь.</p>	<p>70</p>	<p>100</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Шүүх шинжилгээний тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллага нь шинжилгээг шинжилгээний төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглан шинжээч, эсхүл шинжээчдийн багт хуваарилна” гэж заасны дагуу 2023 онд байгууллагын “E-Nifs” нэгдсэн системийг хөгжүүлэн ажиллаж, шинжээч томилох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг шинжээчид цахимаар хуваарилж эхэлсэн.</p> <p>Үүний үр дүнд шинжээчид шинжилгээ цахимаар хуваарилагдахаас эхлээд дүгнэлтээ гаргаж хүргүүлэх хүртэл бүх үйл ажиллагаа хэнээс ч хараат бусаар явагдах боломжтой болсон.</p> <p>Мөн E-NIFS шинжилгээний цахим бүртгэлийн системд ашиглагдах Poweredge R740 серверийг худалдан авч, тохиргоо хийж, ажиллагааны бэлэн байдалд оруулсан. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дотоод сүлжээнд ашиглагдах outlook, lync цахим системийг Poweredge R750xs серверт суурилуулан тохиргоо хийж алба хаагчдыг холбон дотоод сүлжээгээр мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Байгууллагын нэгдсэн системд ерөнхий дизайн зохиомжийг шаардлагын дагуу боловсруулах, нэвтрэх хэсгийн модуль, гарын авлага, мэдээ мэдээлэл харуулах модуль, хүний нөөцийн модуль, хувцас хангалтын модуль, эрхийн тохиргооны модуль, сургалтын модуль, шинжилгээ бүртгэлийн модуль, ажлын хуваарийн модуль зэргийг хийж гүйцэтгэсэн.</p>

<p>3.3. Төрийн мэдээллийн “ХУР” системд холбогдоход хэрэгцээтэй тоног төхөөрөмжийг төв, аймаг, нийслэлийн газар, алба, тасгуудад суурилуулж, холбогдох сургалтыг хийж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлнэ.</p>	<p>Тоног төхөөрөмжийг суурилуулж, холбогдох сургалтыг зохион байгуулсан эсэх.</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдож үйлчлүүлэгч иргэдийн мэдээллийг авч түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг худалдан авч төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системтэй бүрэн холбогдож, хурууны хээ уншигч “ZK-9500” төхөөрөмжийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан тохиргоо хийж, Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын үзлэгийн өрөө, Бүртгэл, мэдээлэл технологийн хэлтэс, дүүргүүдийн шүүх шинжилгээний хэлтэс, орон нутгийн шинжилгээний нэгжүүдэд төхөөрөмжийг суурилуулан, холбогдох сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн сервертэй бүрэн холбож мэдээлэл татан авах кодыг бичиж, төхөөрөмжүүдэд суулган ажиллагаанд оруулсан бөгөөд тус төхөөрөмжийг ашиглан байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн мэдээллийг түргэн шуурхай авч, хүндрэл чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Мөн “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн” нь “Шүүх шинжилгээний ерөнхий газар” болсонтой холбогдуулан байгууллагын www.nifs.gov.mn цахим хуудасны нэр www.nfa.gov.mn болж өөрчлөгдсөн тул төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийн программ хангамжийг дахин программчилсан.</p> <p>Нэгдсэн системд шаардлагатай мэдээллийг харуулахын тулд 2024 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай холбогдон ХУР системийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээг шинэчилж 11 сервисүүдийг нэмж авахаар гэрээний загварыг баталгаажуулан илгээсэн.</p>
<p>3.4. Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахимд шилжүүлнэ.</p>	<p>Эрүүл мэндийн хохирлын зэрэг тогтоох шинжилгээ хийлгэх цаг, Галт зэвсгийн хонгио, хошууны бүртгэлийн болон Салах ёс гүйцэтгэх цагийг цахимаар олгодог болсон эсэх.</p>	<p>0</p>	<p>3</p>	<p>-</p>	<p>Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахимд шилжүүлэх буюу гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийлгэх цаг, галт зэвсгийн хонгио, хошууны бүртгэлийн болон салах ёс гүйцэтгэх цагийг цахимаар олгох ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан байгууллагын веб хуудаст цахимаар цаг авах цэс байршуулсан.</p> <p>Мөн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар буюу “Шинжилгээ хийлгэхтэй холбоотой зөвлөмж”, “Иргэн гэмт халдлагад өртсөн, бие махбодид</p>

					<p>ямар нэг гэмтэл учирсан тохиолдолд тус газарт хэрхэн яаж үзүүлэх, шинжилгээ хийлгэхэд шаардлагатай бичиг баримт” болон “Улсын хилээр нийтэд худалдах зорилгоор оруулж ирсэн иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгээр буудлага үйлдэж хонгио, хошууны дээж авч, санд бүртгэх үйлчилгээ”-ний талаар видео танилцуулгыг байгууллагын цахим хуудас, “facebook”, “youtube” цахим хуудсанд болон дээрх үйлчилгээний мэдээллийг “E-khutuch.mn” цахим санд тус тус байршуулсан.</p> <p>Тус газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилгоор “Нас барсан тухай А7 маяг” авах, “Амбулаторийн үзлэг, шинжилгээг хэрхэн хийлгэх” тухай зөвлөгөө, тайлбар, мэдээллийг багтаасан “QR MENU” шинээр бий болгож үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.</p>
<p>3.5. Аймгийн ШША-ны албадуудын дарга нартай цахимаар холбогдож өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, албадад хийгдэж байгаа ажлын явц, чанар үр дүн, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл солилцож, мэргэжлийн газар, хэлтсийн дарга нар холбогдох мэдээлэл хүргэн тодорхой үүрэг, даалгавар өгөх ажлыг тогтмолжуулна.</p>	<p>Албаны шуурхай бэлэн байдлыг хангах, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай солилцох зорилгоор Аймгийн ШША-ны албадуудын дарга нартай цахимаар сар бүр хурал зохион байгуулсан эсэх.</p>	0	12	-	<p>Төв, орон нутгийн шинжилгээний нэгжийн дарга, алба хаагчидтай 7 хоног тутам цахимаар хуралдаж холбогдох үүрэг чиглэлийг өгч, биелэлт тооцон, ажиллаж хэвшсэн болно. Мөн нэгжүүдэд тулгамдаж байгаа асуудлаар мэргэжлийн газар, хэлтсийн дарга нар үүрэг өгч, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, биелэлт, хэрэгжилт хэрхэн үр дүнд хүрсэн талаар танилцуулга авч ажиллаж байгаа бөгөөд 2022 онд 21, 2023 онд 39, 2024 онд 37 удаагийн цахим уулзалт, хурлыг зохион байгуулсан.</p>
<p>3.6. Байгууллагын цахим хуудсыг бүрэн шинэчилж мэдээ, мэдээллийг байршуулна.</p>	<p>Байгууллагын цахим хуудсыг шинэчилж холбогдох цаг үеийн мэдээ, мэдээллийг байршуулсан эсэх.</p>	0	1	-	<p>Байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбоотойгоор цахим хуудас (https://www.nfa.gov.mn/) болон пейж хуудсыг (Шүүх шинжилгээний ерөнхий газар) шинэчилсэн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг, холбогдох мэдээлэл, зохион байгуулсан ажил, арга хэмжээ зэрэг мэдээ,</p>

					мэдээллийг тухай бүрд нь нийтлэн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.
4. Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.					
<p>4.1. БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар 2020-2023 онд хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн хувь.</p>	30	100	-	<p>Бүгд Найрамдах Солонгос Улсын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламж, тус улсын Аюулгүй байдал, дотоод хэргийн яамны харьяа Үндэсний Шүүх шинжилгээний хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж, сургалт зохион байгуулсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн, сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологи бүхий тус шинжилгээний лабораториудыг хүлээн авах нээлтийн арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Шүүх шинжилгээний ерөнхий газрын төв байрны гадна талбайд зохион байгуулсан.</p> <p>Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Аюулгүй байдал, дотоод хэргийн яамны харьяа Үндэсний Шүүх шинжилгээний хүрээлэнгийн захирал Пак Нам Кютай “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, шүүх шинжилгээний салбарт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагаагаа бататгаж, Гадаад харилцааны яаманд баталгаажуулсан санамж бичгийн хуулбарыг бүртгүүлсэн.</p> <p>Төслийн хүрээнд ДНХ-ийн шинжилгээний лабораторид “26 нэр төрлийн 66 ширхэг тоног төхөөрөмж, 34 нэр төрлийн урвалж бодис, 12 нэр төрлийн туслах хэрэглэгдэхүүн”, Бичиг баримтын шинжилгээний лабораторид “4 нэр төрлийн суурин тоног төхөөрөмж, 1 зөөврийн иж бүрдэл”, Цахим технологийн шинжилгээний лабораторид “22 нэр төрлийн программ хангамж, 10 нэр төрлийн тоног төхөөрөмж”, Химийн шинжилгээний лабораторид “13 нэр төрлийн тоног төхөөрөмж, 27 нэр төрлийн стандарт дээж”-ийг суурилуулж, шинжилгээнд ашиглаж байна.</p> <p>Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсад хийгдэх боломжгүй байсан ахуйн хэрэглээний хийн найрлага</p>

					<p>тодорхойлох шинжилгээ болон биоматериалаас ахуйн хэрэглээний хийг /газ/ илрүүлэх шинжилгээ болон шинээр бүртгэгдэж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох, хүний биеийн яс, шүднээс геномын ДНХ ялган авч, харьцуулах шинжилгээг хийх боломжтой болсон.</p> <p>Үүний үр дүнд ДНХ-ийн шинжилгээний санд бүртгэгдсэн ясанд ДНХ -ийн шинжилгээ хийж, эзэнгүй 2 хэргийн хохирогчийг нотлон ажилласан бол цахим технологийн шинжилгээгээр хөдөлгөөнт төхөөрөмжийн, эх код-өгөгдлийн сангийн, кибер орчны болон цахим технологийн IoT төрөл зэрэг нэмэлтээр 4 нэр төрлийн шинжилгээг шинээр хийх боломж бүрдсэн.</p> <p>Төслийн хүрээнд нийт ДНХ, Хими, Дижитал, Бичиг баримтын шинжилгээний лабораториудын нийт 57 алба хаагчийг БНСУ-ын Үндэсний шүүх шинжилгээний байгууллагад 14-45 хоногийн хугацаатай танхимын сургалтад, 19 алба хаагчийг цахим сургалтад, нийт 76 алба хаагчийг холбогдох сургалтуудад хамруулж, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн.</p>
<p>4.2. БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн хувь.</p>	10	50	Гадаадын зээл тусламж	<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд зөвлөх үйлчилгээ үзүүлэх сонгон шалгаруулалтад “AUM&LEE Architects&Associates” компани шалгарч, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, БНСУ-ын “Aum&Lee Architects & Associates Co, Ltd”-ийн гүйцэтгэх захирал нар төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнд 2023 оны 06 дугаар сард гарын үсэг зурж баталгаажуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/988 дугаар шийдвэрээр Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Архивын ерөнхий газрын баруун урд Үйлчилгээ, контор, шинжилгээний байр барих зориулалттай 1 га газар эзэмших эрхийн гэрчилгээ авч, барилгын зургийг “Зуун</p>

				<p>найм” ХХК-аар, барилга угсралтын төсвийг “Өрх” ХХК-аар хийлгэсэн.</p> <p>Шүүх анагаах ухааны шинжилгээний чиглэлээр БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22 төсөл”-ийн хүрээнд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг “AUM&LEE Architects & Associates” компанитай 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан.</p> <p>Мөн нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хот байгуулалт, хөгжлийн газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар барилгын талбайг томсгох асуудлыг хэлэлцэж, Архитектур төлөвлөлтийн даалгаврыг шинэчилсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 1/967 дугаартай албан бичгээр төсөл хэрэгжүүлэх нэгж, бүтэц орон тоо, түүнд холбогдох зардлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн боловч Сангийн сайдын 2024 оны 01/1583 дугаартай албан бичгээр зээлийн гэрээнд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулахаар тусгайлан заагаагүй тул холбогдох санхүүжилтийг шийдвэрлэх боломжгүй талаар хариу ирүүлсэн.</p> <p>Иймд дээрх нөхцөл байдлыг үнэлэн төслийн зээлийн гэрээнд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах талаар тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/1900 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.</p> <p>Төслийн захирал Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2024 оны 4/1128 дугаартай албан бичгээр төслийн ажилд шинжээч эмч, эд эсийн шинжээч, лаборант, туслах ажилтан нарын чадавхыг дээшлүүлэх сургалтад тусгах саналыг төслийн зөвлөх БНСУ-ын Аум энд Ли Архитектур энд Ассоциаци ХХК-д хүргүүлснээр эхний ээлжинд төв, орон нутгийн шүүх эмнэлэг, шүүх дүрс оношилгоо, шүүх эд эсийн 10 шинжээч эмч нарыг БНСУ-д 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 12 дугаар</p>
--	--	--	--	--

					<p>сарын 07-ны өдрүүдэд эхний ээлжийн сургалтад хамруулж байна.</p> <p>Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импорт банкны төлөөлөгчид 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтэс, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтэс, Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны хэлтсийн удирдлагатай хийсэн уулзалтаар төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулах нь зүйтэй гэж 2 тал үзэж, холбогдох санхүүжилтийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжийг судлахаар тохиролцсон байна.</p> <p>Төсөл хэрэгжих газрын үерийн даланг шилжүүлэхгүйгээр барилгын ажил явагдахад хүндрэлтэй асуудал үүсэхээр байх тул Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих Жаргалантын амны үерийн усны хамгаалалтын ажил Суваг-1-ийн транс зурагт өөрчлөлт оруулж, үерийн хамгаалалтын далан барих ажлыг гүйцэтгэгч Геодоези усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ даланг ухаж, хавтанг байрлуулах ажил энэ оны 8, 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн.</p> <p>Төсөл хэрэгжих газрын дулаан, ус суваг, цахилгаан, мэдээлэл сүлжээний техникийн нөхцөлийг Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-аас авсан.</p> <p>Зам тээврийн яамны Зам тээврийн хөгжлийн төвөөс Магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргасан.Үүнд: Гүүрийн зураг төсөл, Техникийн шаардлага, Гүүрийн барилгын ажлын төсөв, Геодезын тайлан, Геологийн судалгааны тайлан батлагдаж дүгнэлт авсан.</p>
5. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахуйц үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.					
5.1. Шинжилгээний лабораторийг шинэчлэн Олон Улсын стандартад нийцүүлэн техник, технологи, тоног	Шинжилгээний лаборатори болон өрөө тасалгаанд засвар, үйлчилгээ хийсэн тоо.	0	11	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	Тайлангийн хугацаанд 2021 онд ажлын хүрээнд албан хаагч, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, таатай орчин бүрдүүлэх зорилгоор төв байрны 1 дүгээр давхарт бүрэн засвар хийж, үүдний хэсэг болон байрны гадна нүүрийг шинээр засаж,

<p>төхөөрөмжөөр хангаж, мэргэжилтнүүдээ сургаж Олон Улсын шаардлагад нийцсэн мэргэжлийн боловсон хүчинтэй болно.</p>					<p>Криминалистикийн шинжилгээний газрын Галт зэвсэг, Гарын мөр, Автотехник, Мөр судлал, Гэрэл зураг, Дүрс бичлэг, дүр зургийн шинжилгээний лабораториуд, Эдийн засгийн шинжилгээний хэлтэс, Захиргаа, удирдлагын газрын өрөөнүүдийн хана, тааз, шалыг дотоод нөөц бололцоог ашиглан бүрэн засварлаж, албан хаагчдын ажлын ширээг сольж ажиллах нөхцөл боломжийг сайжруулан ая тухтай орчин бүрдүүлж ажилласан.</p> <p>Тус газрын 2 дугаар байрны 1-р давхарт 5 автомашины гражийн зориулалтаар ашиглаж байсан 138 метр квадрат талбайд сантехник, цахилгаан болон дотор засварын ажлыг хийж криминалистикийн шинжилгээний дээж бэлтгэх лабораторийг байгуулж, 60х90 см-ийн ажлын талбайтай “CNC зүсэгч”, 60х90 см-ийн ажлын талбайтай “Laser cutting”, 20х20 см-ийн ажлын талбайтай “3D Printer”, тавцант хөрөө, нуман гагнуур, суурин өрөм, бага оврын төмрийн токарийн машин, зүсэгч машин, цахилгаан болон механик багажийн иж бүрдэл, хатуу зөөлөн материалуудыг таслах, зүсэх, холбох зориулалттай нийт 36 нэр төрлийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулан үйл ажиллагаандаа ашигласан.</p> <p>2022 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд шинжилгээний лабораториудад засвар, үйлчилгээ хийх, стандартад нийцүүлэн шинэчлэн тоноглох, засварын ажлыг төв байрны 2, 5, 6-р давхарт хийж гүйцэтгэсэн.</p>
<p>5.2. Гарын мөрийн шинжилгээний лабораторид гарын мөр илрүүлэх тоног төхөөрөмж худалдан авна.</p>	<p>“Цианакрилатная камер VCA 300L” тоног төхөөрөмж худалдан авсан эсэх.</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв</p>	<p>2021 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Цианакрилатная камер VCA 300L” тоног төхөөрөмжийг тус лабораторид худалдан авч суурилуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Мөн 2023 онд уг төхөөрөмжинд ашиглах нэрмэл ус гаргахад шаардлагатай ус нэрэгчийн төхөөрөмжийг худалдан авах тендэр зарлан, “Грийн химистри ХХК”-тай гэрээ байгуулан, 2024 онд “DZ-5LIII” маркийн нэрмэл</p>

					усны аппаратыг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.
6. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, салбарын санхүүгийн чадавх, менежмент, уялдааг сайжруулна.					
6.1. Шүүхийн шинжилгээний байгууллагад шаардлагатай орон тоог нэмж батлуулна.	Шүүхийн Хүний нөөцийг ажлын ачаалал, цалинтай уялдуулан нэмэгдүүлсэн тоо.	514	990	Улсын төсөв	<p>Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2022 оны А/140 дугаар тушаалаар тус байгууллагын орон тооны дээд хязгаарыг 623 байхаар баталсан. Мөн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдаж, “Агентлаг байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор тус байгууллагыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байхаар шийдвэрлэж, 23 дугаар тогтоолоор “Шүүх шинжилгээний төв байгууллагын зохион байгуулалтын бүтэц-ийг баталсан.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/10 дугаар тушаалаар “Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийг шинэчлэн баталсан бөгөөд Шүүх шинжилгээний ерөнхий газрын орон тоог 118, Нийслэлийн шүүх шинжилгээний газар, хэлтсийн орон тоог 236, Бүсийн шүүх шинжилгээний төвийн орон тоог 335, аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс, хэсгийн орон тоог 152, нийт 841 байхаар заасан бөгөөд 2024 онд цалингийн сан 743 байхаар батлагдсан.</p> <p>Одоогийн байдлаар 9 газар, 6 төв, 33 хэлтэс, 3 тасаг, 10 хэсэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Шүүх шинжилгээний ерөнхий газарт 98, Нийслэлийн шүүх шинжилгээний газарт 270, Бүсийн шүүх шинжилгээний төвд 91, аймгийн Шүүх шинжилгээний хэлтэст 182, нийт 641 алба хаагч, ажилтнууд ажиллаж байна.</p>
6.2. Албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч, шинжээч, шинжээч	Албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч, хувцас	30	70	Улсын төсөв	Засгийн газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор “Агентлаг байгуулах”, 23 дугаар тогтоолоор “Шүүх шинжилгээний төв байгууллагын зохион байгуулалтын бүтэц”, 173 дугаар тогтоолоор “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ” 374 дүгээр тогтоолоор “Цогцост

<p>эмч, туслах ажилтан, лабораторийн ажилтан нарыг хэргийн газрын үзлэг, лабораторийн шинжилгээ хийх үед өмсөх, стандартын шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр хангаж, нийт албан хаагчдыг дүрэмт хувцсаар тасралтгүй хангана.</p>	<p>хэрэглэлээр хангасан хувь.</p>				<p>үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагааг гүйцэтгэсний нэмэгдлийн хэмжээ”, 182 дугаар тогтоолоор “Бүсийн шүүх шинжилгээний төв байгуулах”, 2023 оны 241 дүгээр тогтоолоор “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-г баталсан.</p> <p>“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-г шинэчлэн тогтоосон. Үүний үр дүнд төрийн тусгай албаны бага болон дунд албан тушаалтны цалингийн хэмжээ дунджаар 272.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, адил зэрэглэлд хамаарах алба хаагчдын цалингийн зөрүүтэй байдал арилсан.</p> <p>Шүүх шинжилгээний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2023 оны Б/396 дугаар тушаалаар нийт 64 алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон. Ингэснээр нэг алба хаагчийн цалин 133,400-324,400 төгрөгөөр нэмэгдсэн.</p> <p>Алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажлын хариуцлага, нийгмийн асуудлыг дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх, авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, орон нутгийн шинжээч эмч, криминалистикийн шинжээч болон бусад ахлагч бүрэлдэхүүний нийт 144 алба хаагчийн албан тушаалын цалингийн зэрэглэлийг тус бүр 1 шат нэмэгдүүлж батлуулсан. Мөн ахлагч бүрэлдэхүүнд ажиллаж байгаа нийт 95 алба хаагчийн албан тушаал, цолны ангилал, зэрэглэлийг тус тус нэмэгдүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2023 оны 374 дүгээр тогтоолоор “Цогцост үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагааг гүйцэтгэсний нэмэгдлийн хэмжээ”-г тогтоож, Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2023 оны Б/393 дугаар тушаалаар “Цогцост үзлэг хийх, зөөвөрлөх, задлан шинжлэх ажиллагааг гүйцэтгэсний нэмэгдэл олгох албан тушаал”-ыг баталсан.</p>
--	-----------------------------------	--	--	--	--

				<p>Мөн даргын 2023 оны Б/395 дугаар тушаалаар хүүхэд асрах чөлөө авсан, хүүхэд асрах чөлөөтэй байгаа алба хаагчдад цагдаагийн цолны цалинг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд тайлангийн хугацаанд хүүхэд асрах чөлөөтэй байгаа нийт 22 алба хаагчид цагдаагийн цолны цалинг олгож эхэлсэн.</p> <p>Түүнчлэн Шүүх шинжилгээний тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.12 дахь, 75 дугаар зүйлийн 75.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүсэлт гарган, зөвлөмжийг аймаг, нийслэлийн Нийгмийн даатгалын нэгжүүдэд хүргүүлж нийт 135 ахмад ажилтны ажилласан жилийн тооцооллыг хийж, тэтгэврийг шинэчлэн тогтоолгосон.</p> <p>Нийслэлийн орон сууцны корпорацын “Орон сууц түрээслээд өмчлөх хөтөлбөр”-т тус байгууллагын 5 алба хаагчийг, Нийслэлийн ХУД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа “Хуулийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын орон сууцны цогцолбор хороолол” төслийн 110 дугаар орон сууцанд 4 алба хаагчийг хамруулсан.</p> <p>“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-г шинэчлэн тогтоосон. Үүний үр дүнд төрийн тусгай албаны бага болон дунд албан тушаалтны цалингийн хэмжээ дунджаар 272.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, адил зэрэглэлд хамаарах алба хаагчдын цалингийн зөрүүтэй байдал арилсан.</p> <p>Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/90 дүгээр “Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, цолны зэрэглэл”-ийг шинэчлэн баталсан бөгөөд тус байгууллагын алба хаагчдын албан тушаалын зэрэглэл нэг шат нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын цалинтай дүйцэх хэмжээнд хүрч, офицер бүрэлдэхүүний алба хаагчийн сарын дундаж цалин 1.5-1.6 сая төгрөг, ахлагч бүрэлдэхүүний алба хаагчийн</p>
--	--	--	--	--

					<p>сарын дундаж цалин 1.3-1.4 сая төгрөг болж, адил зэрэглэлд хамаарах алба хаагчдын цалингийн зөрүүтэй байдал арилсан.</p> <p>Шүүх шинжилгээний тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.4, 71 дүгээр зүйлийн 71.12, 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсгийг тус тус үндэслэн алба хаагчдын төрийн тусгай алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцох судалгааг хийж, 269 алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон.</p> <p>Тус газрын даргын 2024 оны Б/437 дугаартай тушаалаар тус байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 13 алба хаагчид дэмжлэг үзүүлж 13.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.</p> <p>“Эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ”-г Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг болон Амармед нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулж, нийт 139 алба хаагчийг хамруулсан.</p> <p>Байгууллагын урсгал зардлаар нормын хувцсанд 2022 онд 622.5 сая төгрөг, 2023 онд 250.0 сая төгрөг, 2024 онд 1,428.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/319 дугаар “Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөө батлах” тухай тушаалын дагуу нормын хувцас худалдан авах тендерийг хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж, байгууллагын нийт 508 алба хаагчдад цагаан цамц, цэнхэр цамц, зуны ботинк олгосон ба мөн нийт 152 алба хаагчдад өвлийн хүрэм өмдийг тус тус олгож ажилласан.</p> <p>Мөн 2024 онд орон нутгийн шүүх шинжилгээний төв, хэлтсийн нийт 268 алба хаагч, Нийслэлийн шүүх шинжилгээний газрын 218 алба хаагч, Шүүх шинжилгээний ерөнхий газрын 95 алба хаагч тус бүрд хүлээн авсан нормын хувцсыг батлагдсан жагсаалтын дагуу анхан шатны баримт үйлдэн олгож ажилласан.</p>
6.3. Байгууллагын жил бүрийн сургалтын төлөвлөгөөг баталж	Захирлын 2017 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Албан хаагчийн сургалтын	0	4	Улсын төсөв, 300.0 сая төгрөг	Байгууллагын жил бүрийн сургалтын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд тайлант хугацаанд 2021 онд 75, 2022 онд 76, 2023 онд 258, 2024

<p>хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>журам"-ыг үндэслэн төлөвлөгөөг боловсруулсан эсэх.</p>				<p>онд 319, нийт 728 сургалтын ажил, арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Зохион байгуулсан ажил, арга хэмжээг төрлөөр нь ангилбал, эрх зүйн чиглэлээр 209, удирдах албан тушаалтанд зориулсан 48, шүүх анагаах ухааны шинжилгээний чиглэлээр 78, байгалийн ухааны шинжилгээний чиглэлээр 53, инженер-техникийн шинжилгээний чиглэлээр 28, криминалистикийн шинжилгээний чиглэлээр 89, эдийн засгийн шинжилгээний чиглэлээр 22, хувь хүний хөгжлийн чиглэлээр, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулах чиглэлээрх бусад 201 сургалтыг зохион байгуулж ажилласан байна.</p>
<p>6.4. Албан хаагчдыг мэргэжил, мэргэшлийн дагуу гадаад дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулна.</p>	<p>Захирлын 2017 оны А/04 дүгээр тушаалаар баталсан "Албан хаагчийн сургалтын журам"-ын дагуу албан хаагчдыг мэргэжил, мэргэшлийн дагуу гадаад дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулсан хувь.</p>	<p>30</p>	<p>70</p>	<p>Улсын төсөв, 400.0 сая төгрөг</p>	<p>Байгууллагын хүний нөөцийг дэлхийн өндөр хөгжилтэй БНЭУ, ХБНГУ, АНУ, Их Британи Улс, БНХАУ, Япон зэрэг улс орнуудын их дээд сургуульд тэтгэлгээр сургаж, бэлтгэхээр холбогдох журмын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p><u>2021 онд хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:</u></p> <p>ОХУ-ын Дотоод хэргийн яамны харьяа Москвагийн их сургууль, Волгоградын академи, Дорнод Сибирийн дээд сургуульд тус байгууллагын 32 албан хаагчийг гарын мөр, мөр судлал, гэрэл зураг, дүр зураг, дүрс бичлэг, бичиг баримт судлал, галт зэвсэг, авто техникийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрууллаа.</p> <p>Мөн БНСУ-ын "КОЙКА" Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн "Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд зохион байгуулсан цахим сургалтад гэрэл зураг, дүрс бичлэг, дүр зургийн болон хими, ДНХ-ийн шинжилгээний лабораториудын нийт 19 шинжээч хамрагдаж, гэрчилгээ авсан.</p> <p><u>2022 онд хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:</u></p> <p>БНСУ-ын "КОЙКА" Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн "Монгол Улсын Шүүх шинжилгээний</p>

				<p>байгууллагын чадамжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд 10 удирдах албан тушаалтан Сөүл хотод зохион байгуулсан туршлага солилцох сургалтад хамрагдсан. Мөн ДНХ, Хими, Дижитал шинжилгээний лабораторийн 12 албан хаагч хамрагдсан.</p> <p>Түүнчлэн Америкийн Шүүхийн шинжилгээний академиас (AAFS) зохион байгуулсан 74 дэх удаагийн чуулга уулзалт, Интерпол (Олон улсын Эрүүгийн Цагдаагийн байгууллага)-оос зохион байгуулсан "INTERPOL DIGITAL FORENSICS PROGRAMME" олон улсын дижитал шинжилгээний эрхийн гэрчилгээтэй цахим сургалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан хүрээлэн буй орчны төслийн хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалт, Индонез улсын нийслэл Жакарта хотод зохион байгуулагдсан Азийн шүүхийн шинжилгээний холбооны 14 дэх удаагийн уулзалт зэрэгт нийт 9 алба хаагч оролцож, туршлага солилцсон.</p> <p>Мөн Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн хууль сахиулах зөвлөх Грант Миллерээр ахлуулсан мэргэжилтнүүд тус байгууллагын шинээр байгуулагдсан "Экологийн шинжилгээний лаборатори"-ийн үйл ажиллагаатай танилцаж, Олон Улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын туршлагыг нэвтрүүлэх, эрдэмтэд хоорондын харилцаа холбоог тогтоох, лабораторийг бэхжүүлэх, шинжээч мэргэжилтэн нарыг мэргэшүүлэх чиглэлээр санал солилцсон бөгөөд тус нийгэмлэгээс зохион байгуулсан "Зэрлэг амьтны хууль бус худалдаа", Мэдээллийг төрөлжүүлэн үнэлэх" сэдэвт сургалтад лабораторийн алба хаагчид хамрагдсан.</p> <p><u>2023 онд хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:</u> 2023 онд БНЭУ-ын Засгийн газрын тэтгэлгээр Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлахуйн институтын 1 дүгээр дамжаанд суралцаж байсан 11 сонсогчийг тус улсын Шинжлэн магадлахуйн үндэсний</p>
--	--	--	--	--

				<p>их сургуульд бакалавр, магистр хөтөлбөрт, Гужаратын Технологийн их сургуульд цахим аюулгүй байдлын чиглэлээр 1 алба хаагчийг суралцуулж эхэлсэн.</p> <p>Дотоод хэргийн их сургуультай хамтарсан ажлын хэсэг байгуулж, Шинжлэн магадлахуйн магистрын “1+1” сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан баталж, 2023 оны 9 дүгээр сараас эхлэн 28 алба хаагчийг сургалтад хамруулж байна.</p> <p>Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Хөгжлийн төлөө хамтын ажиллагааны байгууллагаас (EAPD) зохион байгуулсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймааны эсрэг тэмцэх нь”, ХБНГУ-ын Бавари мужийн Айнринг хот дахь Цагдаагийн давтан сургалтын төвд зохион байгуулсан “Хэргийн газрын үзлэг, ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх”, ДНХ, Хими, Дижитал, Бичиг баримтын шинжилгээний лабораторийн шинжээчдийг БНСУ-ын Үндэсний шүүх шинжилгээний хүрээлэнд, Малайз Улсын Куала Лумпур хотод зохион байгуулагдсан Азийн Шүүх шинжилгээний холбооны 15 дахь удаагийн уулзалт, симпозиум, Тайланд Улсын Бангкок хотод Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (IAEA)-аас зохион байгуулсан “Цөмийн шүүх шинжилгээ”, БНЭУ-ын Засгийн газрын “ИТЕС/е-ИТЕС” хөтөлбөрийн хүрээнд “Гарын мөр, мөр судлал, бичиг баримтын шинжилгээ”, ШУТИС-ийн МХТС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургалтын төв, ЖАЙКА олон улсын байгууллагаас хамтран зохион байгуулсан “Cyber Security Computer Forensic Training Teach Teacher”, БНХАУ-ын Бээжин, Шанхай хотод зохион байгуулагдсан “Удирдлагын манлайлал”, Азийн сан, Үндэсний хүүхдийн эвсэл (NSA)-тэй хамтран зохион байгуулагдсан “Дата мэдээлэл цуглуулах” зэрэг сэдэвт олон улсын сургалт, зөвлөгөөнд нийт 45 алба хаагч хамрагдсан байна.</p> <p>БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн</p>
--	--	--	--	--

				<p>хүрээнд ДНХ, хими, цахим технологи, бичиг баримтын шинжилгээний лабораториудын 19 алба хаагч БНСУ-ын Үндэсний шүүх шинжилгээний байгууллагад 45 хоногийн хугацаатай сургалтад хамрагдсан.</p> <p><u>2024 онд хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:</u></p> <p>БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл /МОН-22/”-ийн хүрээнд төслийн хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 11-нээс 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын барилгын зураг төсөл, дэд бүтэц, цахилгаан эрчим хүч, сантехник болон дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг судлах зорилгоор 5 алба хаагч тус улсад албан томилолтоор ажилласан.</p> <p>Тус төслийн хүрээнд төв, орон нутгийн шүүх эмнэлэг, шүүх дүрс оношилгоо, шүүх эд эсийн 10 шинжээч эмчийг БНСУ-д 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 07-ны өдрүүдэд эхний ээлжийн сургалтад хамруулж байна.</p> <p>Мөн БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд тус улсад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 22-ны өдрүүдэд хэргийн газрын үзлэг, ул мөр эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэх чиглэлээр зохион байгуулагдах 4 дүгээр ээлжийн сургалтад 16 алба хаагчийг сургалтад хамруулсан.</p> <p>Америкийн Нэгдсэн Улсын шинжлэн магадлахуйн академийн 76 дах чуулга уулзалт, тус улсын Хөдөө аж ахуйн газрын Ойн албанаас зохион байгуулсан “Загас, зэрлэг амьтдын үндэсний шүүх шинжилгээний лаборатори”-ийн үйл ажиллагаатай танилцах, харилцан туршлага солилцох практик сургалт, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас хэрэгжүүлдэг Техник, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны /e-ITEC/ хөтөлбөрийн "Байгалийн өвийн менежмент" сургалт, мөн улсад зохион байгуулагдсан “Шүүх шинжилгээний аюулгүй байдал, эрх зүйн олон улсын анхдугаар бага</p>
--	--	--	--	--

					хурал”, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Хөгжлийн төлөө хамтын ажиллагааны байгууллага (EAPD)-аас зохион байгуулсан “Наркотик болон сэтгэцэд нөлөөлөх бодисын эсрэг үйл ажиллагаа” сургалт, Тайланд улсын Хар тамхитай тэмцэх алба, Нийгмийн эрүүл мэндийн яам, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын Олон улсын хар тамхитай тэмцэх, хууль сахиулах алба, “Коломбо” төлөвлөгөөний хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын шүүх шинжилгээний лабораторийн удирдлагуудын Олон улсын 4 дүгээр уулзалт, симпозиум”, мөн улсад зохион байгуулагдсан “Криптовалютын хууль бус хэрэглээг мөрдөн шалгах” сургалт, Япон улсын Ёкохама хотод зохион байгуулагдсан “Анагаах ухаан ба эрүүл мэндийн мэдээллийн олон улсын VIII хурал”, Малайз Улсын Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр болон Зүүн өмнөд Азийн бүс нутгийн терроризмтой тэмцэх төвөөс зохион байгуулсан “Хими, Биологи, Цацраг идэвхт, Цөмийн болон Тэсрэх бодисын Терроризм-101” сургалт зэрэг олон улсын эрдэм шинжилгээний хурал, уулзалт, сургалтуудад нийт 11 улс оронд 74 алба хаагчийг хамруулсан.
6.5. Албан хаагчдыг бакалавр, докторын хамруулна.	Захирлын 2017 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Албан хаагчийн сургалтын журам”-ын дагуу албан хаагчдыг гадаад, дотоодын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтад хамруулсан хувь.	10	30	Улсын төсөв, 300.0 сая төгрөг	<p>2024 оны байдлаар байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн “Шинжлэн магадлахуй” докторын хөтөлбөрийн I дамжаанд 2, II дамжаанд 1, III дамжаанд 1, “Шинжлэн магадлахуй” магистрын хөтөлбөрийн I дамжаанд 4, II дамжаанд 22, нийт 30 алба хаагчийг сургалтад хамруулсан.</p> <p>Байгууллагын алба хаагчдаас докторын хөтөлбөрт 18, магистрын хөтөлбөрт 84 алба хаагч хамрагдаж байна.</p> <p>Байгууллагын захиалгаар Оросын Холбооны Улсын ДХЯ-ны харьяа их, дээд сургуульд бакалаврын хөтөлбөрт 25, Унгар улсад докторын хөтөлбөрт 1, Бүгд Найрамдах Энэтхэг Улсад бакалавр, магистр 10 алба хаагч буюу 3 улсад 36 алба хаагч суралцаж байна.</p>

<p>6.6. “Шүүхийн шинжилгээ” шинжлэх ухаан, практик, танин мэдэхүй, мэдээ мэдээллийн сэтгүүл гаргана.</p>	<p>“Шүүхийн шинжилгээ” шинжлэх ухаан, практик, танин мэдэхүй, мэдээ мэдээллийн товхимлын 2021, 2022, 2023, 2024 оны дугаарын эхийг бэлтгэж, гаргасан эсэх.</p>	<p>0</p>	<p>4</p>	<p>Улсын төсөв, 24.0 сая төгрөг</p>	<p>“Шүүхийн шинжилгээ” мэдээ, мэдээлэл, практик, танин мэдэхүйн улирал тутмын эмхэтгэлийн чанар, үнэлэмжийг дээшлүүлэх, тус сэтгүүлийг хэвлэдэг зардлаар “Шүүх шинжилгээ” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл хэвлүүлэх зорилгоор бусад төрийн байгууллага, их сургуулийн сэтгүүл нийтлүүлэх үйл явцын талаар болон ISSN дугаарын талаар судалгаа хийсэн.</p> <p>Мөн ажлын хүрээнд “Шүүх шинжилгээ” онол, практик, арга зүйн сэтгүүлийн нийтлэлийн бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий Сэтгүүлийн зөвлөлийн үүргийг Шүүх шинжилгээний төв байгууллагын дэргэдэх орон тооны бус эрдмийн зөвлөл хэрэгжүүлэх талаар Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2023 оны А/20 дугаар тушаал, журамд тусгуулж, батлуулсан.</p> <p>“Шүүх шинжилгээ” сэтгүүл бэлтгэн гаргах ажлын хүрээнд тус газрын даргын 2024 оны А/14 дугаартай тушаалаар ажлын хэсгийг байгуулан, шинжлэх ухаан, танин мэдэхүйн эмхэтгэлийг эрхлэн гаргаж, “Чөлөөт хэвлэл сан” хэвлэх үйлдвэрт 1300 хувь хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгосон.</p> <p>Мөн “Шүүх шинжилгээ сургалтын гарын авлага”-ыг бэлтгэн гаргаж, 75 ширхгийг хэвлүүлэн, шүүх шинжилгээний эрх олгох сургалтад хамрагдсан тусгай мэдлэг бүхий иргэдэд тараасан.</p>
<p>ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР:</p>					
<p>Хоёр. Эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн газраас нотлох баримтыг илрүүлэн бэхжүүлж авах, хэргийн газрын ул мөр, эд мөрийн баримтад үзлэг хийх, мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлтээр криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээ, эдийн засгийн шинжилгээ хийж, шинжлэн ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах.</p>					
<p>1. Улсын хэмжээнд хийгдэж байгаа шүүхийн шинжилгээний нэгдсэн бүртгэлийг хөтлөх, шинжээчийн дүгнэлт, шинжилгээний объектын бүрэн бүтэн байдлыг хангах.</p>					
<p>1.1. Аймгийн шүүхийн шинжилгээний албадуудаас илгээх бичгээр ирүүлсэн эд эсийн болон хими, биологийн шинжилгээг хүлээн авч, шинжилгээний хариуг</p>	<p>Шинжээчдийн ажлын ачааллыг багасгах тэнцвэржүүлэх зорилгоор шинжилгээний хариуг илгээсэн эсэх.</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>-</p>	<p>Орон нутгийн шинжилгээний нэгжүүдээс илгээх бичгээр 2021-2024 онд ирүүлсэн эд эсийн 2224 шинжилгээ, хими, биологи, бактериологийн 7284 шинжилгээг тус тус хүлээн авч шинжилгээ хийж, хариуг цахим хаягаар урьдчилан илгээж, эх хувийг шуудангаар хүргүүлэн ажилласан.</p>

цахим хаягаар урьдчилан илгээнэ.					
1.2. Нас барсан тухай гэрчилгээ, салах ёс гүйцэтгэх ажиллагааны үед баримтлах зааварчилгааг тухай бүр талийгаачийн ар гэрт өгч, салах ёс гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна.	Зааварчилгааг тухай бүр талийгаачийн ар гэрт ямар нэг хүндрэл чирэгдэлгүй өгч салах ёс гүйцэтгэх ажиллагааг холбогдох журмын хүрээнд зохион байгуулсан эсэх.	0	1	-	Эрүүл мэндийн сайдын А/611 тушаалаар баталсан “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-07” маягтыг 2021-2024 онд 9189 удаа талийгаачийн ар гэрийнхэнд нь холбогдох баримт бичгийг үндэслэн олгож, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 1866 эмнэлгийн оношны талаарх мэдээллийг гарган өгч ажилласан.
1.3. Аймаг, орон нутгаас ирүүлсэн шинжилгээний хариуг /шинжээчийн дүгнэлт/ хуулийн хугацаанд шуудангаар буцаан илгээнэ.	Шинжээчийн дүгнэлтийг хуулийн хугацаанд буцаан илгээсэн эсэх.	0	1	-	Аймаг, орон нутгийн хууль хяналтын байгууллагаас томилж ирүүлсэн шинжилгээний хариуг /шинжээчийн дүгнэлт/ цаг алдалгүй шуудангаар илгээх ажилд онцгой анхааран ажиллаж, 2021-2024 онд 20247 дүгнэлт болон албан бичгийг 3080 хайрцаг эд мөрийн баримтыг хүргүүлсэн.
1.4. Шинжээч томилох эрх бүхий албан тушаалтнуудын утас, цахим хаягийн санг шинэчлэн, шинжилгээтэй холбоотой мэдээллийг журмын дагуу өгнө.	Шинжээч томилох эрх бүхий албан тушаалтнуудын утас, цахим хаягийн санг тогтмол шинэчлэн, шинжилгээтэй холбоотой мэдээллийг журмын дагуу өгсөн эсэх.	0	1	-	“Шүүх шинжилгээний байгууллагад хийгдэж буй үзлэг, шинжилгээний талаар эрх бүхий албан тушаалтанд мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ын дагуу 2021-2024 онд эрх бүхий албан тушаалтанд 264022, 264020, 266322, 70004022 дугаарын утсаар 17298 удаа шинжилгээний талаарх мэдээлэл, лавлагааг өгсөн.
1.5. Шинжилгээ хийх хугацаанд хяналт тавьж, хугацаа сунгуулах хүсэлтийг эрх бүхий этгээдэд уламжлан шийдвэрлүүлнэ.	Шинжилгээ хийх хугацаанд бүртгэлээр хяналт тавих, хугацаа сунгуулах хүсэлтийг эрх бүхий этгээдэд уламжилсан эсэх.	0	1	-	Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн 2021 онд 58350, 2022 онд 69201, 2023 онд 64266, 2024 онд 68851 шинжилгээ хийсэн бөгөөд тухай бүр шинжилгээ хийх хугацаанд хяналт тавьж ажилласан. Тайлангийн хугацаанд шинжилгээний хугацаа сунгуулах, эх хувь, загвар ирүүлэх зэрэг 14031 албан бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.
1.6. Үзлэг, шинжилгээний явцад харьцуулах шинжилгээнд загвар, дээж нэмж авах болон бусад	Зохих журмын дагуу үзлэг, шинжилгээний явцад харьцуулах шинжилгээнд загвар,	0	1	-	Шинжилгээнд загвар, дээж нэмж авах болон бусад асуудлын талаар 2021-2024 онд эрх бүхий этгээдэд утсаар 10777 удаа, албан бичгээр 17181 удаа хандаж шийдвэрлүүлэн ажилласан.

асуудлыг эрх бүхий этгээдэд уламжлан шийдвэрлүүлнэ.	дээж нэмж авах болон бусад асуудлыг эрх бүхий этгээдэд уламжилсан эсэх.				
<p>1.7. Эрүүл мэндийн байгууллага, Цагдаа, Улсын бүртгэлийн газарт тухай бүр холбогдох статистик мэдээг хүргүүлнэ.</p>	<p>Зохих журмын дагуу улсын хэмжээний статистик мэдээг үнэн зөв, бодитой гаргаж хүргүүлсэн тоо.</p>	4	16	-	<p>Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ЭМТ-501 маягтын дагуу “Health info” программд 2021 онд 1793, 2022 онд 2345, 2023 онд 1760, 2024 онд 3567, нийт 9465 нас барсан иргэний мэдээллийг бүртгэж, дүнг сар бүр илгээсэн.</p> <p>Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 2021 онд 36, 2022 онд 53, 2023 онд 67, 2024 онд 94, нийт 250 нярайн эндэгдлийн мэдээг 7 хоног бүр илгээсэн.</p> <p>Гэмтэл согог судлалын үндэсний төвд 2021 онд 1246, 2022 онд 1543, 2023 онд 1081, 2024 онд 2249, нийт 6299 гэмтлийн улмаас нас барсан иргэний мэдээллийг сар бүр илгээж, “Health info” программд бүртгэсэн.</p> <p>ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газарт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант нас баралт”-ын мэдээ болон “эм, үл үзэгдэх бодист хийгдсэн мансууруулах бодис илрүүлэх шинжилгээ”-ний мэдээг сар бүр цахимаар хүргүүлсэн байна. Мөн 2016-2024 онуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний улмаас нас барсан иргэний тохиолдлын судалгааг гарган Хар тамхитай тэмцэх газарт 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 13/6978 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн “МУ дахь гэмт хэргийн цагаан ном-2021, 2022, 2023” хэвлэлтэд зориулж 2021, 2022, 2023 оны хэргийн газрын үзлэг, шинжилгээ, илрүүлсэн ул мөр, эд мөрийн баримт, сангийн баяжилтын статистик мэдээллийг нэгтгэн ЦЕГ-т тухай бүр хүргүүлсэн.</p> <p>Шүүх шинжилгээний статистик 2021, 2022, 2023 эмхэтгэлийг боловсруулж, үндэсний судалгааны нэгдсэн платформ sudalгаа.gov.mn-д байршуулан, эмхэтгэлийн QR код бүхий танилцуулга бэлтгэн он тус бүрд 100 ширхэг хэвлүүлсэн.</p> <p>Эзэнгүй цогцос оршуулсан талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2024 оны 11 дүгээр</p>

					сарын 29-ний 14/864 дугаар албан бичгээр мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөрдөн байцаах албанд угаарын хийн хордлогоор нас барсан иргэдийн 10 жилийн судалгааг гарган 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 13/2464 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
2. Үзлэг, шинжилгээ нэг бүрийн чанарт онцгой анхаарах, хуулийн хугацааг нарийн баримтлах, шинжээчдийн бие даасан хараат бус байдлыг хангах.					
2.1. Шинжилгээ хийлгэх тогтоол, захирамж, хүсэлтийг хүлээн авч шинжээч болон шинжээчдийн бүрэлдэхүүнд даалгаж, шинжилгээ хийж дууссаны дараа эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгнө.	УЕП-ын 2018 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам”-д заасны дагуу шинжилгээний объектын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж хүлээн авч бүртгэх, тусгай мэдлэг эзэмшсэн байдал, туршлага, ажлын ачааллыг харгалзан шинжээч болон шинжээчдийн бүрэлдэхүүнд даалгах, шинжээчийн гаргасан дүгнэлт болон объектыг эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгсөн эсэх.	0	1	-	<u>2021 онд хийгдсэн шинжилгээ:</u> Криминалистикийн шинжилгээний 89069 объекттой 8766 шинжилгээ, байгалийн ухааны 33638 объекттой 15836 шинжилгээ, шүүх анагаах ухааны 33631 шинжилгээ, эдийн засгийн 191 шинжилгээ шинжилгээ хүлээн авч бүртгэн, шинжилгээ хийж, дүгнэлтийг шинжилгээ томилсон эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч ажилласан. <u>2022 онд хийгдсэн шинжилгээ:</u> Криминалистикийн шинжилгээний 54934 объекттой 8877 шинжилгээ, байгалийн ухааны 91906 объекттой 18456 шинжилгээ, шүүх анагаах ухааны 41699 шинжилгээ, эдийн засгийн 169 шинжилгээ хүлээн авч бүртгэн, шинжилгээ хийж, дүгнэлтийг шинжилгээ томилсон эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч ажилласан. <u>2023 онд хийгдсэн шинжилгээ:</u> Криминалистикийн шинжилгээний 32495 объекттой 7025 шинжилгээ, байгалийн ухааны 42423 объекттой 16397 шинжилгээ, шүүх анагаах ухааны 39881 шинжилгээ, эдийн засгийн 111 шинжилгээ, инженер-техникийн 2951 объекттой 852 шинжилгээ хүлээн авч бүртгэн, шинжилгээ хийж, дүгнэлтийг шинжилгээ томилсон эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч ажилласан. <u>2024 онд хийгдсэн шинжилгээ:</u> Криминалистикийн шинжилгээний 37755 объекттой 7682 шинжилгээ, байгалийн ухааны 64759 объекттой 18202 шинжилгээ, шүүх анагаах ухааны 42801 шинжилгээ, эдийн засгийн 166 шинжилгээ, инженер-техникийн 4889 объекттой 999 шинжилгээ

					хүлээн авч бүртгэн, шинжилгээ хийж, дүгнэлтийг шинжилгээ томилсон эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч ажилласан.
2.2. Хэргийн газрын үзлэгээр нотлох баримт цуглуулж, ул мөр илрүүлэх, бэхжүүлэх, хураан авах ажиллагааг гүйцэтгэнэ.	Захирлын 2017 оны А/02 дугаар тушаалаар баталсан “Хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтыг савлах, битүүмжлэх, хаяглах, бүртгэх журам”-ын дагуу хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож шинжилгээний шаардлага хангахуйц ул мөр эд мөрийн баримт илрүүлэн бэхжүүлэх, хураан авсан эсэх.	0	1	-	<p>Байгууллагын хэмжээнд хэргийн газрын үзлэгт 2021 онд 27702, 2022 онд 32460, 2023 онд 28906, 2024 онд 32740 удаа буюу нийт 121808 удаа хэргийн газрын үзлэгт оролцсон.</p> <p>Мөн хэргийн газрын үзлэгээр 2021 онд 54668, 2022 онд 32460, 2023 онд 28906, 2024 онд 32740 ширхэг буюу нийт 148774 ширхэг ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэн авч ажилласан.</p>
2.3. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн криминалистикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргана.	Гарын мөр, мөр судлал, бичиг баримт, галт зэвсэг, тэсрэх төхөөрөмж, авто техник, компьютер судлал, экологи, материал судлалын шинжилгээг үнэн зөв, бодитой хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	<p>Шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжээчид 2021 онд гарын мөрийн 5384, мөр судлалын 1394, бичиг баримтын 684, галт зэвсгийн 677, тэсрэх төхөөрөмжийн 2, автотехникийн 226, компьютер судлалын 77, материал судлалын 40, бусад 9, экологийн 1 шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан.</p> <p>2022 онд гарын мөрийн 5249, мөр судлалын 1300, бичиг баримтын 902, галт зэвсгийн 736, тэсрэх төхөөрөмжийн 6, автотехникийн 261, компьютер судлалын 100, материал судлалын 48, бусад 33, экологийн 92 шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан.</p> <p>2023 онд гарын мөрийн 3486, мөр судлалын 1349, бичиг баримтын 1513, галт зэвсгийн 632, тэсрэх төхөөрөмжийн 18, компьютер судлалын 43, материал судлалын 19, бусад 8, автомашины эвдрэл гэмтлийг тогтоох 152, зам тээврийн ослын нөхцөл байдлыг сэргээн тогтоох 218, хурд тодорхойлох 67, хэсгээс</p>

					<p>бүхлийг тогтоох 6, тээврийн хэрэгслийн явагч хэсгийн 18, автомашинаас бусад техникийн 29, хөдөлгөөнт төхөөрөмжийн 85, цахим орчны 6, өгөгдлийн сангийн 4, хүрээлэн буй орчны 247 шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан.</p> <p>2024 онд гарын мөрийн 4041, мөр судлалын 1369, бичиг баримтын 626, галт зэвсгийн 574, тэсрэх төхөөрөмжийн 1, компьютер судлалын 57, материал судлалын 28, бусад 44, автомашины эвдрэл гэмтлийг тогтоох 243, зам тээврийн ослын нөхцөл байдлыг сэргээн тогтоох 148, хурд тодорхойлох 42, хэсгээс бүхлийг тогтоох 6, тээврийн хэрэгслийн явагч хэсгийн 9, автомашинаас бусад техникийн 117, хөдөлгөөнт төхөөрөмжийн 109, цахим орчны 14, цахим технологийн 2, инженер-техник 1, хэргийн газрыг сэргээн дүрслэх 9, өгөгдлийн сангийн 5, хүрээлэн буй орчны 310 шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан.</p>
<p>2.4. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн криминалистикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргана.</p>	<p>Дүр зураг, дуу авиа, дүрс бичлэгийн адилтгалын шинжилгээг үнэн зөв, бодитой хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.</p>	0	1	-	<p>Шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжээчид хүний гадна дүр төрхийн шинжилгээг 2021 онд 15, 2022 онд 21, 2023 онд 32, 2024 онд 33, нийт 101 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.</p> <p>Дүрс бичлэгийн шинжилгээг 2021 онд 243, 2022 онд 204, 2023 онд 178, 2024 онд 188, нийт 813 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.</p> <p>Дуу авианы шинжилгээг 2021 онд 15, 2022 онд 17, 2023 онд 14, 2024 он 16, нийт 62 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.</p>
<p>2.5. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх бусад ажиллагаанд оролцоно.</p>	<p>Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн хүрээнд оролцсон эсэх.</p>	0	1	-	<p>Криминалистикийн шинжээчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагаанд буюу цогцосны үзлэгт 2021 онд 4922, 2022 онд 5773, 2023 онд 6452, 2024 онд 7582 удаа буюу нийт 24729 удаа оролцсон.</p> <p>Задлан шинжилгээнд 2021 онд 3003, 2022 онд 3319, 2023 онд 2499, 2024 онд 2646 удаа буюу нийт 11467 удаа оролцсон.</p> <p>Эксгумацид 2021 онд 17, 2022 онд 11, 2023 онд 16, 2024 онд 12 удаа буюу нийт 56 удаа оролцсон.</p> <p>Мөрдөн байцаалтын туршилт болон бусад ажиллагаанд 2021 онд 2946, 2022 онд 4207, 2023 онд</p>

					3181, 2024 онд 4286 удаа буюу нийт 14620 удаа ажиллагаанд оролцсон байна.
2.6. Галт зэвсгийн хонгио, хошууны “Абис-Арсенал” системийн санг баяжуулна.	Галт зэвсгийн хонгио, хошууны санг баяжуулсан эсэх.	0	1	-	Галт зэвсгийн “Абис-Арсенал” санг 2021 онд 5013 хонгио, 3464 хошуугаар, 2022 онд 4109 хонгио, 3669 хошуугаар, 2023 онд 3407 хонгио, 2840 хошуугаар, 2024 онд 1869 хонгио, 1503 хошуугаар буюу тайлангийн хугацаанд нийт 14398 хонгио, 11476 хошуугаар тус тус баяжилт хийж ажилласан. Гарын мөрийн “Адис-Папило” гарын мөрийн нэгдсэн санг 2021 онд 42487 дардас, 8617 мөр, 2022 онд 35853 дардас, 8680 мөр, 2023 онд 25403 дардас, 6278 мөр, 2024 онд 11450 дардас, 6514 мөрөөр буюу тайлангийн хугацаанд нийт 115193 дардас, 30089 мөрөөр тус тус баяжилт хийж ажилласан.
2.7. Гарын мөрийн сан бүрдүүлж “Адис-Папило” ажлын станцын санг баяжуулна.	Гарын мөрийн санг баяжуулсан эсэх.	0	1	-	
2.8. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг үнэн зөв, бодитой хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	Тайлангийн хугацаанд 2021 онд шинжээч эмч нар 4915 удаа хэргийн газрын болон цогцосны үзлэгт оролцож, 4561 цогцост задлан шинжилгээ, 22949 хүнд гэмтлийн зэрэг тогтоох, 69 хүнд нас тогтоох, 1617 хүнд бэлгийн холбогдолтой үзлэг шинжилгээ, хавтаст хэргийн материалаар 1178, эксгумацийн 11, эд эсийн 3246 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна. 2022 онд шинжээч эмч нар 5352 удаа хэргийн газрын болон цогцосны үзлэгт оролцож, 5353 цогцост задлан шинжилгээ, 10 эксгумаци, 29010 хүнд гэмтлийн зэрэг тогтоох, 81 хүнд нас тогтоох, 2021 хүнд бэлгийн холбогдолтой үзлэг шинжилгээ, 1401 хавтаст хэргийн материалаар, 3823 эд эсийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. 2023 онд шинжээч эмч нар 5435 удаа хэргийн газрын болон цогцосны үзлэгт оролцож, 5231 цогцост задлан шинжилгээ, 14 эксгумаци, гэмтлийн зэрэг тогтоох 26337, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох 149, нас тогтоох 104, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой 2018 үзлэг шинжилгээ, хавтаст хэргийн материалаар 1398, бичил амь судлалын 1394, эд эсийн 2990 хийж, дүгнэлт гарган ажилласан. 2024 онд шинжээч эмч нар 6333 удаа хэргийн газрын болон цогцосны үзлэгт оролцож, 5605 цогцост задлан шинжилгээ, 12 эксгумаци, 27226 хүнд гэмтлийн
2.9. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн хүний биед бэлгийн холбогдолтой болон нас тогтоох шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Хүний биед бэлгийн холбогдолтой болон нас тогтоох шинжилгээг үнэн зөв, бодитой хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	
2.10. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн цогцост задлан шинжилгээ болон эксгумаци хийж, дүгнэлт гаргана.	Цогцост задлан шинжилгээ болон эксгумаци хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	
2.11. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн хэргийн материалаар шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргана.	Хавтаст хэргийн материалаар шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	

					зэрэг тогтоох, 99 хүнд нас тогтоох, 1988 хүнд бэлгийн холбогдолтой үзлэг шинжилгээ, хавтаст хэргийн материалаар 1571, эд эсийн 3722, сэтгэцэд учирсан хор хохирлын 1159, бичил амь судлалын 1419 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.
2.12. Шинжээч эмчийн илгээх бичгийн дагуу эд эсийн шинжилгээг хийнэ.	Шинжээч эмчийн илгээх бичгээр ирүүлсэн эд эсийн шинжилгээг үнэн зөв, бодитой хийж хариуг буцаан хүргүүлсэн эсэх.	0	1	-	Шинжээч эмчийн илгээх бичгийн дагуу 2021 онд 3246, 2022 онд 3823, 2023 онд 2990, 2024 онд 3722, нийт 13781 шүүх эд эсийн шинжилгээ хийж, хариуг хүргүүлсэн.
2.13. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн хими, физик, биологи, ДНХ-ээр эцэг тогтоох болон ДНХ-ийн бусад шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Хими, физик, биологи, ДНХ-ээр эцэг тогтоох болон ДНХ-ийн бусад шинжилгээг үнэн зөв, бодитой хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	2021 онд хийгдсэн шинжилгээ: химийн 6931, физикийн 133, биологийн 5977, ДНХ-ээр эцэг тогтоох 452, ДНХ-ийн бусад 1305, бактериологийн 1038, нийт 15836 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. 2022 онд хийгдсэн шинжилгээ: химийн 8091, физикийн 150, биологийн 6504, ДНХ-ээр эцэг тогтоох 575, ДНХ-ийн бусад 1665, бактериологийн 1379, нийт 18364 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. 2023 онд хийгдсэн шинжилгээ: химийн 7814, физикийн 179, биологийн 6360, ДНХ-ээр эцэг тогтоох 418, ДНХ-ийн бусад 1379, хүрээлэн буй орчны 247, нийт 16397 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. 2024 онд хийгдсэн шинжилгээ: химийн 8658, физикийн 233, биологийн 6215, ДНХ-ээр эцэг тогтоох 286, ДНХ-ийн бусад 2500, хүрээлэн буй орчны 310, нийт 18202 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.
2.14. Бактериологийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Бактериологийн шинжилгээг үнэн зөв, бодитой хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.	0	1	-	Бактериологийн шинжилгээ 2021 онд 1038, 2022 онд 1379, 2023 онд 1394, 2024 онд 1419, нийт 5230 шинжилгээ хийж, дүгнэлт гарган хуулийн хугацаанд хүргүүлсэн.
2.15. ДНХ-ийн мэдээллийн санг баяжуулна.	ДНХ-ийн мэдээллийн санг баяжуулсан эсэх.	0	1	-	“ДНХ-ийн мэдээллийн нэгдсэн сан”-г 2021 онд 1626, 2022 онд 1236, 2023 онд 899, 2024 онд 1243, нийт 5004 хүний генетик мэдээллээр баяжуулсан.
2.16. Эрх бүхий этгээдийн томилсон тогтоол, захирамжийг үндэслэн	Эдийн засгийн шинжилгээг үнэн зөв, бодитой хийж шинжлэх	0	1	-	Эдийн засгийн шинжээчид эрх бүхий байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамжийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох өмчийн болон татварын холбогдолтой хэрэгт 2021 онд 191, 2022 онд

эдийн засгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан эсэх.				169, 2023 онд 111, 2024 онд 166, нийт 637 шинжилгээ хийж, 4,714,056,895.9 тэрбум төгрөгийн, 945,025,046.1 валютын зөрчил тогтоож, дүгнэлт гарган хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.
2.17. Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцсыг оршуулна.	Хэн болох нь тогтоогдоогүй болон хариуцах эзэнгүй хүний цогцсыг 30 хоног хүртэл хадгалж журмын дагуу оршуулсан эсэх.	0	1	Гүйцэтгэлээр	Засгийн газрын 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим цогцос оршуулах журам”-ын дагуу 2021 онд 55, 2022 онд 96, 2023 онд 80, 2024 онд 116 хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй, нийт 347 цогцсыг журмын дагуу оршуулсан.

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР